

## УЛС ТӨРИЙН ХЯМРАЛ СУДЛАЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДАЛ, УЛС ТӨРИЙН ХЯМРАЛД НӨЛӨӨЛЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ, АНГИЛАЛ

Г.Туяагэрэл

*ХААИС-ийн Нийгмийн ухааны тэнхмийн багш, докторант*

Улс төрийн хямралыг улс төрийн мөргөлдөөний нэгэн үе шат мэтээр авч үзэж тайлбарлах хандлага түгээмэл байдаг. Үнэн хэрэгтээ үйл явцын өрнөлийн логик дарааллыг нь авч үзвэл: Зөрчил-мөргөлдөөн-хямрал гэсэн үйл явцын дагуу өрнөдөг байна. Харин зарим судлаачид бүтээлдээ улс төрийн хямралыг улс төрийн судалгааны биеэ даасан объект гэж үзээд улс төрийн хямралыг мөргөлдөөнтэй харьцангуй ойролцоо агуулгатайгаар тайлбарлах хандлага байдаг. Гэхдээ улс төрийн хямралыг нөхцөлдүүлэгч хүчин зүйл нь мөргөлдөөн хэдий ч мөргөлдөөнгүйгээр улс төрийн хямрал үүсэх боломжтой учраас улс төрийн хямралыг бие даасан улс төрийн үйл явц гэж үзэх нь зүйтэй юм.

Улс төрийн хямралын үе шатыг цаг хугацааны хувьд авч үзэхийн тулд мөргөлдөөний хөгжлийн үе шаттай харьцуулан үзэх хэрэгтэй юм. Улс төрийн хямралын эхний шатанд харилцаан оролцогч талуудын ашиг сонирхол үзэл бодлын зөрчилдөөн үүсдэг. Дэвшүүлэн тавьж байгаа бодлогыг дэмжих үү аль эсхүл шинэ бодлогыг боловсруулан тавих уу гэх мэт үзэл бодлын зөрчилдөөн үүсдэг гэсэн үг юм. Хоёрдугаар шатанд талуудын аль нэг нь нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд эсрэг талаа шүүмжлэх улмаар өдөөн турхирсанаар “улс төрийн тэсвэрлэшгүй байдал”-ыг үүсгэдэг.

Улс төрийн хямрал ба улс төрийн хямралт нөхцөл байдлыг ойлгохын тулд улс төрийн нөхцөл байдал гэдэг ойлголтыг авч үзэх хэрэгтэй юм. Улс төрийн нөхцөл байдал гэдэг ойлголтын дор чухам юуг ойлгож болох вэ? Улс төрийн нөхцөл байдал гэдгийг улс төрийн систем ба тодорхой нэг цаг хугацаан дах системийн элементүүдийн харилцан үйлчилсэний үр дүн юм гэж үдэг. Тэгвэл улс төрийн нөхцөл байдал гэдэг нь тодорхой нэг цаг хугацаан дах улс төрийн орон зайн нэг бүрдэл болж байдаг гэсэн үг юм. Улс төрийн нөхцөл байдлыг тодорхойлохын тулд нийгмийн болон улс төрийн системийг бүрдүүлж байгаа улс төрийн бүхий л дүрүүдийн харилцан үйлчлэлийн үр дүнг авч үзэх хэрэгтэй болж байгаа юм. Ийнхүү дүрүүдийн харилцан үйлчилсэний үр дүнд үүсч болох эерэгээс сөрөг хүртэлх нөхцөл байдлыг судалсанаар үүсч болох хямралт нөхцөл байдлын ерөнхий дүр зураг улмаар түүнийг шийдвэрлэх үр дүнтэй арга технологийг боловсруулах боломжтой болно гэсэн үг юм.

Барууны улс төр судлаачдын бүтээлд улс төрийн нөхцөл байдал гэдгийг улс төрийн институтууд хоорондын төвшинд хийгээд тэдгээр институтын дотоодод элементүүдийн хоорондын харилцан үйлчилсэний үр дүнд үүсэх нөхцөл байдал<sup>3</sup> гэж тодорхойлсон байдаг. Улс төрийн нөхцөл байдал нь дараах хоёр параметраар тодорхойлогддог. Энэ нь нэгдүгээрт тухайн улс оронд оршин тогтнож байгаа улс төрийн дэглэм, хоёрдугаарт улс орны дотоод түгшүүрт байдлын хэм хэмжээ юм. Орчин үед улс төрийн нөхцөл байдлыг

<sup>3</sup> Никовская Л.И. Проблема кризиса с точки зрения конфликтолога. Выпуск 26. М., 2003. с.78

тодорхойлохдоо улс төрийн харилцаанд оролцогч субъектийн үйл байдлыг авч үзэхийн зэрэгцээ төрийн санхүүгийн нөхцөл байдал, төр ба ард түмнийг холбож байдаг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүгээр дамжигдан олон түмэнд хүрж байгаа мэдээллийн бодит байдлын түвшинтэй холбогдуулан авч үзэж байна. Улс төрийн харилцаанд оролцогч субъектийн идэвхижилтээс улс төрийн нөхцөл байдал ихээхэн шалтгаалдаг ч энэ нь улс төрийн хямралт нөхцөл байдлыг шууд тодорхойлогч хүчин зүйл гэж үзэх боломжгүй юм. Улс төрийн харилцаанд оролцогч субъектүүд нь гүйцэтгэх засаглалын төвшинд өөрсдийн ашиг сонирхлыг дэмжүүлэхийн тулд улс төрийн элиттэй хамтран ажиллах чадвартай тийм сөрөг хүчин байж чадах юм бол парламентаар дамжуулан хууль тогтоох үйл ажиллагаанд дам байдлаар оролцох боломжтой болдог. Уг нөхцөл байдалд нөлөөлөх үүрэгтэй хүчин зүйл бол олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл байдаг.

Улс төрийн хямрал нь засаглалын үл хүлээн зөвшөөрөгдөх шинжийн нэгэн илрэл болдог. Улс төрийн эрх мэдэл нэг субъектэд төвлөрснөөр засаглалын бусад субъектүүдийн хооронд харилцан үйлчлэх, харилцан бие биенийхээ үйл ажиллагаанд хяналт тавих боломж байхгүй болж улмаар улс төрийн удирдлага ба түүнийг хянах нийгмийн хяналтын процессын үр ашигтай байдал алдагдаж улс төрийн эсэргүүцлийн чимээгүй хэлбэрт шилждэг байна (жагссал, цуглаан, ажил хаялт гэх мэт). Ийм нөхцөл байдалд улс төрийн системд өөрийгөө хадгалан үлдэх, бодлогын түвшинд хувирган өөрчлөлт хийх чиг үүргийн хэрэгцээ улам бүр ихэсдэг байна. Улс төрийн хямрал нь улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх явц дах тодорхой бус байдал, санхүүгийн чадвар ба цаг хугацааны хүрэлцээгүй байдал болон бусад үүсч болох олон улс төрийн эрсдэлийн түвшинг нэмэгдүүлж байдаг ба тухайн эрсдэлийн түвшин ямар байх вэ гэдэг нь шийдвэрийг хүлээж авч байгаа нийгмийн массын сэтгэл зүйн байдлаас шууд шалтгаалдаг ажээ. Улс төрийн хямрал нь дараах гурван үе шатыг дамждаг байна. Улс төрийн хямралын урьдач нөхцөл байдал-Улс төрийн хямралын үе-Улс төрийн хямралын дараах үе юм.

Улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн хямрал судлалын онол арга зүйг дараахь үндсэн гурван хэсэгт хуваан авч үзсэн байдаг. Үүнд:

1. Мөргөлдөөний хандлага
2. Модернизацийн хандлаг
3. Системийн хандлага

1.Мөргөлдөөний шинж төрх бүхий нийгмийн харилцаа ба үйл ажиллагаа нь улс төрийн хямралыг дагуулах нь нийгэмд элбэг байдаг. Улс төрийн хямралыг тодорхойлох гол шинжүүд нь санамсаргүй, гэнэтийн, огцом хурдан өрнөдөг, олон хэлбэртэй, урьдчилан хэлэх боломжгүй, түүнийг шийдвэрлэх нь энгийн биш гэх мэт эдгээр шинжүүд юм. Уг шинжүүдийг хямралаас үүсэх сөрөг үр дагаваруудаас олж харж болно. Улс төрийн хямрал ба улс төрийн мөргөлдөөн гэдэг ойлголтуудын хоорондын ялгааг тодорхойлсоноор орчин үеийн шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоонд хямрал ба мөргөлдөөн нь хоюулаа аливаа нэгэн систем ба бүтцийн хөгжлийн үйл явцын нэгэн үе шат учраас түүнээс ангид

орших боломжгүй жам ёсны үзэгдэл гэж үзэх нэгдсэн хандлагыг төлөвшүүлсэн. Ральф Дарендорфыг мөргөлдөөн судлалд энэ хандлагыг бий болгосон судлаачдын нэг гэж үздэг. Тэрээр аливаа систем өөрийгөө хадгалан үлдэх, хувирган өөрчлөх явцдаа жам ёсны энэхүү үзэгдлийг даван туулдаг хэмээн бүтээлдээ авч үзсэн байна. Мөргөлдөөн гэдэг бол даван туулах ёстой жам ёсны үзэгдэл гэдгийг Р.Дарендорф тодорхойлсон байна<sup>4</sup>. Дарендорф нийгмийн мөргөлдөөний онолдоо мөргөлдөөний тухай ойлголтуудыг цэгцэлж чадсан юм. Түүний үзсэнээр нийгмийн бүтцийг тодорхойлж байгаа дурын хоёр элементийн хувьд ч мөргөлдөөн үүсэх боломжтой юм. Мөргөлдөөний талаарх аливаа үзэл санаа нь нийгмийн бүлгүүд ба үндэсний төрүүдийн хүрээнд хязгаарлагдсан шинжтэй байдаг.

Макроконфликтологийн үүднээс авч үзэл улс төрийн хямрал гэдэг нь сүйрлийн өмнөх дохио юм. Хямралын цаана сүйрлийн шинж агуулагдаж байдаг учраас хямралаас гарч хуучин байдалдаа эргэж орох нь тэр хэмжээгээрээ бэрхшээлтэй тулгардаг. Учир нь сүйрэл нь өөрийн гэсэн дүрэм журмын дагуу явагддаг зүй тогтолт үзэгдэл юм<sup>5</sup>.

Улс төрийн хямралыг улс төрийн мөргөлдөөнөөс ялгах нэг онцлог шинж нь мөргөлдөөнд оролцогч талууд нь тооны хувьд 2 ба түүнээс дээш байдаг бол улс төрийн хямралын субъект нь нэг байж болдог.

Улс төрийн хямрал ба улс төрийн асуудал хэмээх ойлголтуудыг авч үзэхийн тулд улс төрийн асуудал гэдэг энэ нэр томъёог аль салбарт өргөнөөр хэрэглэдгийг судлах хэрэгтэй юм. Улс төрийн асуудал гэдэг энэ ойлголт нь улс төрийн шинжлэх ухаан дах олон нийттэй харилцах харилцаанд өргөн ашиглагддаг байна.

Г.Чейз, Б.Джонс нар асуудал гэдгийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. “Асуудал гэдэг нь шийдвэрлэхэд бэлдэж байгаа хараахан шийдвэрлэгдээгүй байгаа асуулт юм”<sup>6</sup>

Улс төрийн хямрал гэдэг нь улс төрийн нөхцөл байдлын хүндэрсэн шинжийг илэрхийлж байдгаараа улс төрийн асуудал гэдэг ойлголтоос ялгагдаж байгаа бөгөөд улс төрийн хямрал нь шийдвэрийг шууд хүлээж авахыг шаарддаг мөн нийгмийн гүнд маш томоохон өөрчлөлтүүдийг хийдэг.

2. Модернизаци ба глобализацийн онолын хүрээнд хийгдсэн улс төрийн хямралын талаарх судалгаа шинжилгээний ажил. Энэ нь С.Хантингтоны “Соёл иргэншлийн мөргөлдөөн”-ийн онолд тусгагдсан улс төрийн хөгжлийн сөрөг үр дагаврыг тодорхойлсон тэр үеэс эхлэлтэй юм. Л. Биндер, Дж.С. Колеман, Дж.Ла. Поллобар, Л.Пай, С.Верба, М. Вейнер нарын бүтээлээс тэдний улс төрийн хямралын талаарх үзэл баримтлалыг харж болох юм. Улс төрийн хямрал гэдэг бол янз бүрийн улс орнууд дах модернизаци ба хөгжлийн процессын явцад үүсэн бий болж байдаг<sup>7</sup> гэсэн санаа тэдний бүтээлд байдаг.

<sup>4</sup> Дарендорф Р. Элементы теории социального конфликта // Социс. 1994. №5. с. 143

<sup>5</sup> Никовская Л.И. Проблема кризиса с точки зрения конфликтолога // Россия в условиях трансформаций. Историко-политологический семинар Выпуск 26. М., 2003. с. 17

<sup>6</sup> Chase W.H. Issues Management: Origins of the Future. Stamford, 1984. p.48

<sup>7</sup> Binder L. Crises and Sequences in Political Development. Princeton, 1971; Хантингтон С. Столкновение цивилизаций. М., 2003

Улс төрийн хямралын талаарх судалгаа нь улс төрийн модернизаци, улс төрийн хөгжил ба улс төрийн аюулгүй байдал гэх мэт ойлголтуудтай холбоотой. Аюулгүй байдлын тухай шинэ үзэл санаа нь нийгмийн хөгжлөөр дамжуулан аюулгүй байдлыг хангахад гол анхаарал хандуулсан байдаг. Аюулгүй байдлын талаар шинэ үзэл санаа бүрэлдэхээс өмнө аюулгүй байдлын тухай үзэл санаа нь эдийн засагт суурилсан хөгжлийн бодлогоор дамжуулан тайлбарлагдаж байсан юм. Энэ нь хөгжлийн тогтвортой шинжийг орхигдуулсан байдаг учраас аюулгүй байдлыг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмжих оролдлогыг хийсэн. Тогтвортой хөгжил гэдэг нь нийгмийн аюулгүй байдлыг хүчирхийллийн болоод зөрчил мөргөлдөөний бус аргаар хангах боломжийг олгодог. Аюулгүй байдлын тухай шинэ үзэл санаа нь тогтвортой хөгжлөөр дамжуулан аюулгүй байдлыг хангах нөгөө талаас аюулгүй байдлыг хангаснаар тогтвортой хөгжлийг баталгаажуулах бүрэн боломжтой болно гэсэн санааг давхар агуулж байгаа юм.

3. Улс төрийн шинжлэх ухаанд системийн хандлагын үүднээс улс төрийн хямралыг тайлбарлан судалсан судалгаа шинжилгээний ажлууд хоёрдугаар хэсэгт багтаж байгаа юм. Энд юуны өмнө улс төрийн хямралыг улс төрийн системийн тогтвортой ба тогтвортой бус байдалтай холбон тайлбарласан байдаг. Улс төрийн системийн тогтвортой бус байдал нь аажимдаа улс төрийн хямралыг бий болгох шалтгаан нь болж байдаг. Иймээс улс төрийн хямралыг авч үзэхдээ улс төрийн хөгжил ба улс төрийн өөрчлөлт гэх ойлголтуудтай холбон авч үзсэн байдаг.

Улс төрийн систем дэх хямралыг авч үзэхдээ тухайн системийн бүрдэл хэв маягийг шууд тодорхойлж байдаг улс төрийн дэглэмийн мөн чанарыг авч үзсэн байдаг. Нийгэмд өөрчлөлтийг ямар аргаар хийж байна вэ гэдэг нь улс төрийн системд үүсэх боломжтой хямралын ерөнхий төрхийг шууд тодорхойлж байдаг. Улс төрийн хямралын талаарх орчин үеийн үзэл баримтлал төлөвшихөөс өмнө улс төрийн өөрчлөлтийг зөвхөн хувьсгалын тусламжтайгаар хийх боломжтой гэж тайлбарлаж байсан. Улс төрийн өөрчлөлт бол хувьсгал юм гэж үзээд үүнээс бусад нэр томъёог улс төрийн хөгжил гэдэг ойлголтод хамруулж үзсэн байдаг. Улс төрийн хөгжил ба улс төрийн өөрчлөлт хэмээх ойлголтуудын энэ тодорхойгүй шинж нь тэднийг судлан тогтоох зайлшгүй шаардлагатай бий болгодог. Иймээс орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн систем дэх өөрчлөлт гэдгийн цаана засгийн газрын өөрчлөлтөөс эхлээд бодлогын түвшин дэх хувирган өөрчлөлт хүртэлх бүхий л өөрчлөлтүүдийг багтаан үзэх бөгөөд тэдгээрийг судлан тогтоох оролдлогуудыг хийсээр байгаа нь улс төрийн өөрчлөлт бол үйл явцын аль ч түвшинд өрнөх боломжтой болохыг харуулж байна<sup>8</sup>.

С.Липсет “Улс төрийн тогтвортой бус байдал нь тухайн системд зөрчил, харилцан үл ойлголцох байдлыг авчирсанаар хямрал үүсэх суурийг тавьдаг. Зарим тохиолдолд улс төрийн элитүүд энэ зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэхийг оролддог ч олонхийн эсэргүүцэлтэй тулгарсанаар хүчин

<sup>8</sup> Ильин М.В. Ритмы и масштабы перемен. О Понятиях “процесс, изменение, развитие” в политологии //Полис. 1993. №2. с. 59

мөхөсддөг. Гэтэл уламжлалт хаант засаглал ба тогтвортой бус ардчилалын үед элитүүд авторитари дэглэмийнхээ тусламжтайгаар зорилгодоо хүрж чаддаг. Иймээс ардчилалыг тогтвортой зөв төлөвшүүлэх нь тухайн улс төрийн системийг нийтээр хүлээн зөвшөөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх юм”<sup>9</sup> гэж үзсэн байдаг.

Улс төрийн хямрал нь улс төрийн үйл явц болохынхоо хувьд улс төрийн системд зорилго ба үнэт зүйлсээ тогтоох гэсэн улс төрийн хүчнүүдийн өрсөлдөөн юм. Улс төрийн амьдрал нь динамик шинжтэй учраас тэгш ба тэгш бус байдал хоюулаа нэгэн зэрэг оршин байж болдог. Энэ байдлаас шалтгаалаад улс төрийн системийн хөгжил нь тогтвортой ба тогтвортой бус шинжийг өөртөө агуулж байдаг гэсэн үг юм. Улс төрийн хямралаас гарахын тулд дараах хоёр нөхцлийг авч үзэх хэрэгтэй болдог. Нэгдүгээрт нийгэм дэх түгшүүрийг арилгах замаар улс төрийн хямралыг зохицуулах, хоёрдугаарт улс төрийн хямралыг зохицуулсанаар улс төрийн системийн тогтвортой хөгжлийг хангах тухай асуудал юм.

Улс төрийн хямралын тухай үзэл санаа нь улс төрийн системийн тогтвортой байдал гэдэг ойлголттой холбоотой юм. П.Н. Кондратьев улс төрийн системийн тэнцвэртэй байдал гэдэг ойлголтод тухайн системийн гадаад ба дотоод өөрчлөлтийг авч үзсэн байна. Гэхдээ улс төрийн системийн тэнцвэртэй, тогтвортой байдал гэдэг нь харьцангуй шинжтэй ойлголт юм. Улс төрийн системийн статик ба динамик, тэнцвэртэй байдал ба тэнцвэртэй бус байдлын тухай үзэл санааг Н.Д.Кондратьев, Ю.В. Яковец нар бүтээлдээ авч үзсэн байдаг. Гэхдээ улс төрийн системийн дээрх төлөв байдлын ялгааг авч үзэхийн тулд статик ба динамик улс төрийн тогтвортой байдлыг судлах шаардлагатай. Статик тогтвортой байдал гэдэг нь улс төрийн системийн бүрдлийг нэг түвшинд хадгалан үлдэх гэсэн эрмэлзэлийг илэрхийлсэн ойлголт юм. Харин динамик тогтвортой байдал гэдэг нь системийн бүрдлийг хөгжлийн дараагийн шатанд гаргах гэсэн системийн эерэг хөгжлийн үр дүн ажээ. Улс төрийн системийн тогтвортой байдлын тухай үзэл санаа нь шилжилтийн үед нийгэм ба улс төрийн системийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах тухай оролдлого юм.

Улс төрийн системийн тогтвортой байдал гэдэг ойлголтын дор системийн хөгжлийн үр дүнг удаан хугацаанд хадгалан үлдэхийн тулд түүний элементүүдийн харилцан үйлчлэлийг зохистой төвшинд барьж байх тухай үзэл санааг авч үздэг. Үүнээс үзэхэд тогтвортой байдал гэдэг нь улс төрийн системийн хөгжлийн үр дүн биш юм. Гэхдээ улс төрийн системийн тогтвортой байдлыг дээд төвшинд хангахын тулд системийн хөгжлийг хангах нь чухал. Улс төрийн системийн тогтвортой байдлын төвшин нь системийг үйл явдлын болоод бодлогын түвшинд хувирган өөрчлөх өөрчлөлтийн хэм хэмжээнээс шууд шалтгаалдаг. Гэхдээ аливаа систем нь өөрийнхөө бүтцийг хадгалан үлдэхийн тулд тухайн нөхцөл байдалд дасан зохицох аль эсвэл хувиран өөрчлөх өөрчлөлтийг бүтэцдээ хийх шаардлагатай болдог байна. Аливаа системийн хувьд туйлын тогтвортой байдал гэж байх боломжгүй юм. Иймээс системийн

<sup>9</sup> Lipset S.M. Political man. The social bases of Politics. Garden City; New York, 1960. p. 78

бодит байдлыг авч үзэхийн тулд системийн тогтвортой байдлын хэм хэмжээ хэрхэн хангагдсан байгааг авч үзэх хэрэгтэй<sup>10</sup>.

А.И.Соловьев улс төрийн тогтвортой байдал гэдэг нь тухайн системийн зорилго гэж үзсэн байдаг. Иймээс улс төрийн системийн зөвхөн нэг төлөв байдал нь улс төрийн тогтвортой байдал юм. Тогтвортой байдал хэмээх ойлголт нь улс төрийн үйл явцын нэгэн төлөв байдал учраас харьцангуй шинжийг агуулж байдаг. Улс төрийн систем нь нийгмийн нэг организм болохынхоо хувьд ямар ч нөхцөлд өөрийгөө хадгалан үлдэх хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрүүлэх<sup>11</sup>, улс төрийн үр ашигтай удирдлагаар хангуулахыг эрмэлзэж байдаг<sup>12</sup>. Харин улс төрийн тогтвортой бус байдал гэдэг нь прадокс шинжийг агуулж байдаг хэмээн Д.Аптер “Улс төрийн өөрчлөлт” гэсэн номондоо тэмдэглэсэн байдаг. Хөгжлийн харилцан адилгүй үе шатанд байгаа янз бүрийн улс орнууд улс төрийн өөрчлөлт хийх явцдаа байнга тулгарч байсан улс төрийн системийн нэг төлөв бол тогтворгүй байдал юм<sup>13</sup>.

Улс төрийн системийн тогтвортой байдал, улс төрийн өөрчлөлт гэх ойлголтууд нь улс төрийн модернизацийн онол, транзитологийн онол, нийгмийн хувьсгал, тогтвортой хөгжлийн онолуудын гол ойлголт болж байдаг учраас тэр хэмжээгээр улс төрийн хямрал гэх ойлголт нь дээрх онолуудтай тодорхой хэмжээгээр хамааралтай байдаг.

Улс төрийн хямралыг системийн аргаар судлан үзвэл нийгмийн систем дэх шилжилтийн үйл явцын нэг үе гэж ойлгож болохоор байна. Хэрвээ системийн бодлогын түвшинд хувирган өөрчлөх үйл явц нь маш эрчимтэй богино хугацаанд өрнөвөл системийн үзүүлэлтүүд нь тэрхүү өөрчлөлтийн улмаас хямралын нөхцөл байдалд орох боломжтой болдог. Ийм гарцаагүй нөхцөл байдал бүрэлдсэн тохиолдолд систем дотоод тогтвортой байдлаа хадгалан үлдэхийн тулд системийн бүхэллэг байдлаа нэн тэргүүнд хангах хэрэгтэй юм.<sup>14</sup>

Улс төрийн хямралын талаарх дийлэнх судалгаа шинжилгээний ажилд тухайн нөхцөл байдалд хямралын ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх нь бүлгийн үйл байдлаас ихээхэн шалтгаалдаг талаар авч үзсэн байдаг. Нийгэм-улс төрийн хямралын шинж тэмдэг нь ихэнхдээ түүнийг бүрдүүлэгч элементүүд болох нийгмийн гишүүд, үндэстэн-угсаатан, шашны бүлэглэлүүдийн үйл байдал хэрхэн өөрчлөгдсөнөөр тодорхойлогддог<sup>15</sup>.

Улс төрийн хямралын сонгодог ангилалуудын нэг нь түүний улс төрийн системд нөлөөлөх нөлөөллөөр нь ангилсан дараах ангилал юм. Үүнд:

1. Системийн дотоод хямрал. Энэ нь системийн өөрийнх нь дотоод элементүүдийн хоорондын харилцан үйлчлэлийн явцад үүсэн бий

<sup>10</sup> Володенков С.В. Моделирования динамики политических процессов в нестабильных системах.- <http://pr.philos.msu.ru/volod.html>

<sup>11</sup> Bealay F. Stability and Crisis: Fears about threats to democracy// European journal of Political research, 1987. Vol 15. №6. p.687

<sup>12</sup> Zimmerman E. Government stability in six European countries during the world economic crisis of the 1930's: some preliminary considerations// European journal of political research. 1987. Vol.15. №1. p. 342

<sup>13</sup> Дегтярев А.А. Основы политической теории. М., 1998. с. 197

<sup>14</sup> Соловьев А.И. Политическая стабильность м социокультурном измерении: российские иллюстрации.//Государственное управление. Электронный вестник. 2003. №1 //http://www.spa.msu.ru/e-journal/1/20\_1.php

<sup>15</sup> Кузьмин С.А. Социальные системы: опыт структурного анализа. М., 1996. с. 140

болдог улс төрийн хямралын нэгэн хэлбэр юм. Жишээ нь: Улс төрийн нам доторх лидерүүдийн эрх мэдлийн төлөөх өрсөлдөөнөөс үүсэх намын дотоод эрх мэдлийн хямралыг үүнд нэрлэж болох юм. Улс төрийн хямралын энэ хэлбэр нь тухайн системийн дотоод өөрчлөлтийн үйл явцтай шууд хамааралтай байдаг.

2. Систем хоорондын хямрал. Улс төрийн хямралын энэ хэлбэр гол төлөв бодлого үйл ажиллагаа, зорилго арга хэрэгсэл, үнэт зүйлийн түвшин харьцангуй ойролцоо улс төрийн системүүдийн хооронд жишээлбэл нэг төвшний улс орнуудын хооронд аль эсвэл нэг улсын доторх бүс нутгуудын хооронд үүсдэг байна. Систем хоорондын хямрал үүссэнээр олон улсын тавцан өрсөлдөөний талбар болж түүн дээр нь өрсөлдөгч хоёр ба хэд хэдэн системүүд бий болдог.
3. Системийн гадаад хямрал. Энэ тохиолдолд улс төрийн хямралын шалтгаан нь тухайн улс төрийн системийн өөрийнх нь үйл ажиллагааны хил хязгаарын гадна байна. Систем өөрийн дотоод үйл ажиллагаанаасаа бус гадаад хүчин зүйлээс шалтгаалан хямарч болох юм.

Улс төрийн хямралын мөн чанар нь төрийн дээд эрх мэдлийг хуваарилах, тэнцвэржүүлэх үйл явцад нийгмийн улс төрийн институт ба бүлэг, байгууллагуудын хоорондын харилцан үйлчилсэний үр дүнд тэдгээрийн хооронд харилцан үл ойлголцох байдал үүссэнээр зөрчил бий болж байдгаар тодорхойлогддог. Иймээс улс төрийн хямрал гэдэг нь нийгмийн улс төрийн системийг бүрдүүлж байдаг төрийн удирдлага ба улс төрийн засаглал институт ба бүтэц, тэдгээрийн өөрчлөлтийн үйл явцыг хангаж байдаг нийгэм-улс төрийн нэгэн үзэгдэл юм.

Улс төрийн хямралын агуулга гэдэг нь улс төрийн хүрээн дэх шилжилтийн үйл явцтай холбогдон үүсч байдаг бүхий л үзэгдэл, үйл явцыг хэлдэг.

Улс төрийн хямралд өөрийн гэсэн бүтэц бий. Улс төрийн хямралын бүтцийн элементүүдийн харилцан хамаарал нь түүний өрнөлийн үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Улс төрийн хямралын субъект гэдэг нь улс төрийн ашиг сонирхолын хувьд харилцан зөрчилдсөн талуудыг хэлдэг. Улс төрийн хямралын субъектүүд нь улс төрийн систем дэх өөрчлөлтийг хийж эрх ашигийн зөрчилдөөнийг үүсгэж байдаг улс төрийн харилцааг тээгчид юм. Улс төрийн хямралын субъектүүд нь улс төрд эзлэх байр суурь гүйцэтгэх үүргээсээ шалтгаалаад улс төрийн амьдралд нөлөөлөх шинж байдал ба нөлөөллийн хэмжээ нь харилцан адилгүй байдаг. Иймээс улс төрийн хямралын субъектүүдийг нийгмийн ба институциональ хэмээн ангилдаг. Нийгмийн субъект гэдэгт нийгмийн янз бүрийн бүлэглэлүүд, улс төрийн элит, сонирхлын бүлгүүд, мэрэгжлийн бүлгүүдийг нэрлэдэг бол институциональ субъектэд төр ба түүний байгууллагууд, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад зохион байгуулалттай бүлгүүдийг авч үздэг байна. Улс төрийн хямралын субъектүүдийн хооронд үүсэх улс төрийн харилцаа нь үгүйсгэсэн, харилцан эвлэрсэн гэх мэт олон хэлбэртэй байж болно.

## ДҮГНЭЛТ

Улс төрийн хямралын мөн чанарыг ойлгохын тулд нийгмийн хамгийн бага нэгжээс эхлүүлээд нийгмийг бүхэлд нь судлах шаардлагатай юм. Улс төрийн орон зай, улс төрийн үйл явцаас эхлүүлээд улс төрийн хямрал үүсэх боломжийг хүртэл судлах хэрэгтэй юм. Улс төрийн хямрал хэмээх ойлголт нь эрсдэл, мөргөлдөөн ба улс төрийн асуудал гэсэн ойлголтуудтай шууд утгаараа холбоотой байдаг. Гэвч хямрал гэдэг нь өөрийн гэсэн онцлог шинж бүтэцтэй байдгаараа улс төрийн бусад үйл явцаас ялгагддаг байна. Улс төрийн эрсдэл ба асуудал нь улс төрийн хямралын шууд үр дагавар юм.

Улс төрийн хямралыг ойлгохын тулд улс төрийн системийн тогтвортой байдал ба тогтвортой бус байдал, гэсэн ойлголтуудыг авч үзэх хэрэгтэй. Тэр тусмаа улс төрийн системийн тогтвортой байдал нь нийгэмд улс төрийн хямрал үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл болдог гэдгийг чухалчлах хэрэгтэй юм.

**Түлхүүр үг:** Улс төрийн хямрал, Улс төрийн хямралын ангилал, Улс төрийн хямралын хэв шинж

**Товч хураангуй:** Нийгэм-улс төрийн хямралыг ойлгохын тулд түүнийг судлах аргазүй, онол практикын ач холбогдлыг авч үзэх нь зүйтэй юм. Улс төрийн хямралыг судлах арга зүй нь уг ойлголт бүрэлдэн тогтсон улс төрийн сэтгэлгээний хөгжлийн түүхийн эхэн үеэс өнөөдрийг хүртэл судлагдсаар байна. Оросын улс төрийн шинжлэх ухаанд энэ сэдвээр хийсэн судалгаа шинжилгээний ажил харьцангуй их байдаг. "Платон, Аристотель, Монтескье, Гегель, Кант, Аристотель нар төр улс доторх хямралт, түүнээс гарах муу үр дагавар, үүнээс сэргийлэх боломжийн талаар өөрсдийн бүтээлдээ тусгасан байдаг. Хамгийн гол нь тэд нар бүгд хямралт нөхцөл байдлын үед улс төрийн шийдвэр гаргах арга зүйн асуудлыг авч үзсэн байдаг"<sup>16</sup>.

"Барууны улс төрийн шинжлэх ухааны төлөөлөгчид болох Г.Лассуэлл, К.Манхейм нар улс төрийн шийдвэр гаргах үйл явцыг судлах арга зүй, тухайн шийдлээс хүлээгдэж буй бодит үр ашигийн талаар авч үзсэн байдаг бол З.Фрейд, Э.Фромм, Г.Маркуз нар улс төрийн шийдвэрийг хүлээж авах нийгмийн ухамсар, сэтгэлзүйн онцлог шинж тэдгээрийн харилцан үйлчлэл, ухамсарын тогтсон хэлбэрүүдийн талаар авч үзсэн байдаг"<sup>17</sup>.

## РЕЗЮМЕ

Для понимания сущности политического кризиса исследование предлагает выстраивать логику от общего к частному: от исследования политического пространства и политических процессов и до исследования непосредственно политического кризиса. Исследование политических кризисов, в основном ведется в рамках двух теорий теории модернизации и теории систем. Кризис - это понятие, напрямую связанное с проблемой, риском, конфликтом. Но кризис имеет свои четко выраженные характеристики, что позволяет выделить его из этого ряда схожих понятий. Понятие политического кризиса напрямую связано с понятиями устойчивых и неустойчивых состояний политической системы, а также с понятиями стабильности и нестабильности политической системы. Именно нестабильность и является фактором возникновения политических кризисов в обществе.

<sup>16</sup> Жебелев.С.А, Гаспаров.М.Л, Аристотель Политика, М, 2005, с.25.

<sup>17</sup> Серебрянников В.В. Принятия политических решений в экстремальных ситуациях. М., 2003, с.5



## НОМ ЗҮЙ

1. Анатомия кризисов/ А.Д. Арманд, Д.И. Люри, В.В. Жерихин и др. М.: Наука, 1999.
2. Антикризисный менеджмент. Превентивные методы управления / А.Б.Крутик, А.И.Муравьев. Изд-во: Питер. 2001.
3. Барсамов В.А. Политические кризисы и смуты (История, теория, современность). М.: МИИТ, 1996.
4. Барсамов В.А. Структура общественно-политического кризиса (теоретический и прикладной анализ). М.: МИИТ, 2002.
5. Большой Энциклопедический словарь/ <http://dic.akademic.ru>.
6. Глоссарий. Служба тематических толковых словарей/ <http://www.glossary.ru/>